УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 05 өдөр Дугаар 6/59 Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энхжаргалын Ганзоригийг 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөр тасалбар болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын туслахын үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс эхлэн Пүрэвийн Оргилыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын туслахаар томилсугай.

2. П.Оргилыг АА-9 зэрэглэлийн 3-р шатлалаар албан тушаалын цалинг 613669 /зургаан зуун арван гурван мянга зургаан зуун жаран ес/ төгрөгөөр тогтоож, онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар, хоол, унааны хөнгөлөлтийг зохих журмын дагуу тооцож олгохыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Б.Тамирт зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2010 оны 10 сарын 12 өдөр Дугаар Б/62 Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Лхамаасүрэнгийн Раднаасүрэнг өөр ажилд томилогдсонтой нь холбогдуулан Уул уурхайн яамны Түлшний бодлого, зохицуулалтын газрын даргын /хуучнаар/ үүрэгт ажлаас 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Л.Раднаасүрэнтэй зохих журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгахыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Б.Тамирт даалгасугай.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2010 оны 10 сарын 11 өдөр Дугаар Б/61 Улаанбаатар хот

Гэрээ дуусгавар болгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9, Монгол Улсын Иргэний хуулийн 364 дүгээр зүйл, 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр ажиллуулагчтай байгуулсан “Хөлсөөр ажиллуулах гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байсан Наранцэцэгийн Гүнжмаатай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээг өөрийнх нь хүсэлтийн нь дагуу 2016 оны 10 дугээр сарын 10-ны өдрөөс эхлэн дуусгавар болгосугай.

2. Н.Гүнжмаагийн ажлыг хүлээлцүүлж холбогдох тооцоог хийж дуусгахыг Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Д.Батхүү/-т, “Төрийн үйлчилгээ” УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Б.Тамирт тус тус даалгасугай.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

08 0153

2016 10 18 б/68

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг 9.8, Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6 дахь хэсгийн 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Нэргүйн Мөнхтуяагийн хүүхдийн эмчилгээний зардалд нь зориулж тусламж үзүүлэхийг хүссэн өргөдлийг нь үндэслэн /300.000 /гурван зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжийг яамны төсвийн зохих зардлаас гаргахыг “Төрийн үйлчилгээ” УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 10 сарын 24 өдөр Дугаар Б/74 Улаанбаатар хот

Ахлах мэргэжилтнээр томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/7421 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн бодлогын газрын мэргэжилтэн Тэгшээгийн Зууннастыг Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтнээр, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Гансүхийн Мөнгөнзулыг Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтнээр 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн тус тус томилсугай.

2. Т.Зууннастын цалинг ТЗ-8 зэрэглэлийн 5-р шатлалаар 795935 (долоон зуун ерэн таван мянга есөн зуун гучин таван) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, зэрэг дэвийн нэмэгдэл 20 хувь, Г.Мөнгөнзулын цалинг ТЗ-8 зэрэглэлийн 5-р шатлалаар 795935 (долоон зуун ерэн таван мянга есөн зуун гучин таван) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, зэрэг дэвийн нэмэгдэл 20 хувь, хоол, унааны хөнгөлөлтийг зохих журмын дагуу тооцож олгохыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Б.Тамирт зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 24 өдөр  Дугаар Б/75

## Ажлаас чөлөөлж, тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3,Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалт, Засгийн газрын "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн яам татан буугдаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан Уул уурхайн яамны /хуучнаар/ Хяналт-шинжлгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Доржсүрэнгийн Жавхланболдыг 2016 оны 10 дугаар сарын 25 -ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Д.Жавхланболдтой холбогдох тооцоог хийж, 3 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгохыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий ня-бо Б.Тамирт зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

08 0214

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 24 өдөр                    Б/76

Ажлаас чөлөөлж, тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3,Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалт, Засгийн газрын "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн яам татан буугдаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан Уул уурхайн яамны /хуучнаар/ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батаагийн Батхүүг 2016 оны 10 дугаар сарын 25 -ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Б.Батхүүтэй холбогдох тооцоог хийж, 3 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгохыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий ня-бо Б.Тамирт зөвшөөрсүгэй.

ДАРГА                    Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 24 өдөр                    Дугаар Б/77

Ажлаас чөлөөлж, тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалт, Засгийн газрын "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн яам татан буугдаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан Уул уурхайн яамны /хуучнаар/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Нэмэхбаярын Энхбаярыг 2016 оны 10 дугаар сарын 25 -ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Н.Энхбаяртай холбогдох тооцоог хийж, 3 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгохыг "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын ерөнхий ня-бо Б.Тамирт зөвшөөрсүгэй.

ДАРГА                    Г.НАНДИНЖАРГАЛ

ТУШААЛ

2016 10 24 Б/78

Ажилд томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01/7630 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цогтзандангийн Анударийг Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтнээр 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Ц.Анударийн цалинг ТЗ-7 зэрэглэлийн 2 дугаар шатлалаар 627465 /зургаан зуун хорин долоон мянга дөрвөн зуун жаран таван/ төгрөгөөр тогтоож хоол, унааны хөнгөлөлтийг зохих журмын дагуу тооцож олгохыг “Төрийн үйлчилгээ” УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 01 өдөр                Дугаар Б/80

Төрийн албанаас түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.2 дахь заалт, мөн хуулийн 23.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн яамны /хуучнаар/ Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ажиллаж байсан Баярсайханы Тунгааг гадаадад мэргэжлийн дагуу магистрын сургалтад суралцах болсонтой нь холбогдуулан 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн төрийн албанаас түр чөлөөлсүгэй.

2. Б.Тунгаатай холбогдох тооцоог хийж, түүний суралцах хугацааны жилд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож, нийгмийн даатгалын санд төлж байхыг Төрийн үйлчилгээ УҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА                Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016.11.07                                        5/83

Хүүхэд асрах чөлөө сунгах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхайн яамнаас /хуучнаар/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдэлд шилжиж ирсэн хүүхэд асрах чөлөөтэй байгаа мэргэжилтэн Нямсүрэнгийн Нарангэрэлийн өргөдлийг нь үндэслэн хүүхэд асрах чөлөөг 2016 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 2017 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар сунгасугай.

ДАРГА                    Г.НАНДИНЖАРГАЛ

2016 11 07 6/82

## Ажилд томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/7823 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Пүрэвдоржийн Хүрэлхүүг Түлшний бодлогын газрын мэргэжилтнээр 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. П.Хүрэлхүүгийн цалинг ТЗ-7 зэрэглэлийн 5 дугаар шатлалаар 733863 /долоон зуун гучин гурван мянга найман зуун жаран гурван/ төгрөгөөр тогтоож зэрэг дэвийн нэмэгдэл 22 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, хоол, унааны хөнгөлөлтийг зохих журмын дагуу тооцож олгохыг “Төрийн үйлчилгээ” ТӨҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

[illegible]

ТӨРИЙН [illegible]

ТУШААЛ

2016 . 11 . 11 Б/89.

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Түлшний бодлогын газрын мэргэжилтэн Б.Лхамсүрэн нь 2016 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр амаржиж хүүтэй болсон тул өргөдлийг нь үндэслэн албан тушаалын цалингийн 50 хувь болох 366000 /гурван зуун жаран зургаан мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжийг яамны төсвийн зохих зардлаас гаргахыг “Төрийн үйлчилгээ” ТӨҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

2016 11 07 б/82

## Ажилд томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/7823 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Пүрэвдоржийн Хүрэлхүүг Түлшний бодлогын газрын мэргэжилтнээр 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. П.Хүрэлхүүгийн цалинг ТЗ-7 зэрэглэлийн 5 дугаар шатлалаар 733863 /долоон зуун гучин гурван мянга найман зуун жаран гурван/ төгрөгөөр тогтоож зэрэг дэвийн нэмэгдэл 22 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, хоол, унааны хөнгөлөлтийг зохих журмын дагуу тооцож олгохыг "Төрийн үйлчилгээ" ТӨҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Б.Тамир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ